



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

*2024.10.17* № *01/2742*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД**

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**

Тус компаниас 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зарласан ЭТТХК/20240102020 дугаартай "Хог хаягдал шатаах зуух" нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалттай холбоотой ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна.

Үүнд:

| Дд | Тодруулга  | Тодруулгын хариу   |
|----|--|--|
| 1  | Техникийн тодорхойлолтоос харахад энэхүү шатаах зуух нь ялгарах хорт хий, тортог цэвэрлэх байгууламжгүй байх юм уу? Зөвхөн давхар шаталттай шатаах камер л байхад болох юм уу?             | Техникийн тодорхойлолтод давхар шаталттай шатаах камертай зуух гэж тусгагдсан. Давхар шаталттай шатаах камер нь шаталтын үед ялгарах хорт хийгээ өндөр температураар өөрөө шатаадаг, шүүлтүүртэй. Хог хаягдлыг шатаах үед ялгарах утаа нь MNS 6342:2012 стандартын шаардлага хангах тохиолдолд заавал хорт хий, тортог цэвэрлэх байгууламжтай байхыг шаардахгүй.   |
| 2  | Яг ямар төрлийн хог хаягдал шатаах вэ? Аюултай хог хаягдал болон химийн бодисын үлдэгдэл шингэн хог хаягдал шатаах юм уу үгүй юу? Хэрэв тийм бол заавал цэвэрлэх байгууламжтай байх ёстой. | Тос маслоор бохирдсон нэг удаагийн хамгаалалтын хувцас, бээлий, арчих материал, картон цаас, агаар шүүгч, тосны шүүр, хуучирсан ажлын хувцас гэх мэтийг шатаана.<br>Манай уурхай нь химийн бодис ашигладаггүй тул химийн бодисын сав баглаа, боодлын хаягдал гардаггүй. Аюултай шингэн хог хаягдал буюу ашигласан тос маслыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагад гэрээний дагуу шилжүүлдэг тул шатаадаггүй.   |
| 3  | Танай техникийн тодорхойлолт дутуу боловсруулагдсан биш үү?  | Хог хаягдлын тухай хуулийн 23-р зүйлд заасны дагуу үүссэн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, тодорхой хугацаанд түр цэг дээр хадгалдаг. Үйл ажиллагааны үед үүссэн хог хаягдлыг бага бага хэмжээгээр шатааж устгахад иж бүрэн технологийн циклтэй шатаах зуух буюу бага оврын хог шатаах үйлдвэр шаардлагагүй. Харин хэрэглээндээ тааруулж давхар шаталтат шатаах камер бүхий зуух хэрэгтэй байгаа болно. |

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 10.3-т заасны дагуу дээрх нэмэлт өөрчлөлтүүд нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124045077